



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

### Нийшилийн аудитын тайлан

#### Баигаль орчныг хамгаалах тухай хуулиин хэрэгжилт



**Өвөрхангай аймагт байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх  
арга хэмжээний хөрөнгийг хуульд заасан хувь хэмжээсээр  
тооцдоггүй, байгаль орчныг бохирдуулж, доройтуулах  
зөрчлүүд гарсаар байна.**

2016 он

# АГУУЛГА

<p><b>Үндэсний аудитын газрын харьяа Өвөрхангай аймгийн аудитын газар</b></p> <p><b>Тайланг бэлтгэсэн:</b></p> <p><b>Дарга, тэргүүлэх аудитор</b> <b>Д.Рэнцэнханд</b></p> <p><b>Аудитын менежер</b> <b>Ц.Оргонням</b></p> <p><b>Ахлах аудитор</b> <b>Д.Гансух</b></p> <p><b>Аудитор</b> <b>П.Хорлоосүрэн</b></p> <p><b>Шинжээч</b> <b>Ө.Ринчинмядаг</b></p> <p><b>2016 оны 10 дугаар сарын 07-ны өдөр</b></p> <p><b>Уг тайланг АГ-ын Веб сайт-аас үзнэ үү.</b> <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p><b>Аудитын тайлан,</b> <b>дүгнэлттэй холбоотой</b> <b>асуудлаар нэмж тодруулах,</b> <b>асууж лавлах зүйл байвал</b> <b>70323801 дугаарын</b> <b>утас, 70323253 дугаарын</b> <b>факсаар харилцана уу</b></p> <p><b>ХАЯГ:</b></p> <p><b>(Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 5 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон 402 тоот)</b></p>	<p><b>Төвчилсон үгийн тайлбар</b></p> <p><b>Нийтлэг үндэслэл</b></p> <p><b>Бүлэг А. Аймгийн ИТХурал болон Засаг даргаас байгаль орчныг хамгаалах талаар хуульд заасан үүргээ хэрэгжүүлж ажилласан ч байгаль орчныг бохирдуулах, доройтуулах зөрчлүүд гарсаар байна.</b></p> <ul style="list-style-type: none"><li><b>Аймгийн ИТХурал нь нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохицой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөөв баталж, биелэлтэд хяналт тавих бүрэн эрхээ хэрэгжүүлж ирсэн байна.</b></li><li><b>Аймгийн Засаг дарга нь нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохицой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ болоевсруулж, аймгийн ИТХуралд өргөн мэдүүлж, гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулан ажиллаж байгаа ч байгаль орчныг бохирдуулах, доройтуулах зөрчлүүд гарсаар байна.</b></li></ul> <p><b>Бүлэг Б. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу төлөвлөсөн ч төлөвлөлтийн үндэслэл бодитой биш, орлогын гүйцэтгэл төлөвлөснөөс 3.6-4.1 хувиар тасарсан байна.</b></p> <ul style="list-style-type: none"><li><b>Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлтийн үндэслэл бодитой биш байна.</b></li><li><b>Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэл сүүлийн 3 жилийн байдлаар 95.9-96.4 хувиийн биелэлттэй буюу төлөвлөснөөс 3.6-4.1 хувиар тасарсан үзүүлэлттэй гарсан байна.</b></li></ul> <p><b>Бүлэг В. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хуваарилсан хөрөнгө хуульд зааснаас доогуур хувиар тооцсон ч хуваарилсан хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу зарцуулсан байна.</b></p> <ul style="list-style-type: none"><li><b>Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хувь хэмжээг хуульд зааснаас 2014 онд 2.1-40.1 хувь, 2015 онд 0.6-79.0 хувиар тус тус доогуур тооцсон байна.</b></li><li><b>Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээний доод хязгаараас 2.1-79.0 хувиар доогуур тооцож, Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.3-т заасан арга хэмжээний хүрээнд зарцуулсан байна.</b></li><li><b>Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээний доод хязгаараас 0.6-29.7 хувиар доогуур тооцсон болоч Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.2-т заасан арга хэмжээний хүрээнд зарцуулсан байна.</b></li><li><b>Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр тооцогддоггүй ба ан амьтны нөөц ашигласны</b></li></ul>
---	--

	<p>төлбөрийн орлого хуульд заасан хувь хэмжээний доод хязгаараас 40.1-45.5 хувиар доогуур тооцсон ч Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.4-т заасан арга хэмжээний хүрээнд зарцуулжээ.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Байгалийн нөөц ашигласны төлбөр төлөгчийг төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх нөхцөл, болзол, хувь хэмжээг орон нутгийн нөхцөл, онцлог байдлыг харгалзан хуульд заасны дагуу шийдвэрлэсэн байна.</li> </ul> <p><b>Бүлэг Г. Байгаль хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд орон нутгийн удирдлага, хэлтэс, албадаас дотоод хяналтыг хуулийн дагуу зохих түвшинд хэрэгжүүлсэн байна.</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдсэн байна.</li> <li>• Байгаль орчныг хамгаалах хуулийн хэрэгжилтэд аймаг, сумдын Засаг дарга нар болон холбогдох хэлтэс, албад, байгаль орчны хяналтын улсын байцаагчид хяналтаа зохих түвшинд гүйцэтгэж ирсэн байна.</li> </ul> <p><b>Дүгиэлт:</b> Өвөрхангай аймагт байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хөрөнгийг хуульд заасан хувь хэмжээгээр тооцдоггүй, байгаль орчныг бохирдуулж, доройтуулах зөрчлүүд гарсаар байна.</p> <p><b>Тайлан баталгаажуулсан тушаал</b></p> <p><b>Дүгнэлт</b></p> <p><b>Холбогдох байгууллагын санал</b></p> <p><b>Хавсралт судалгаанууд</b></p>
--	--

## ТОВЧИЛСОН УГИЙН ЖАГСААЛТ

<b>МУ</b>	<b>Монгол улс</b>
<b>УАГ</b>	<b>Үндэсний аудитын газар</b>
<b>МУЕА</b>	<b>Монгол улсын ерөнхий аудитор</b>
<b>УИХ</b>	<b>Улсын их хурал</b>
<b>БОНХАЖС</b>	<b>Байгаль орчин ногоон хөгжил аялал жуулчлалын сайд</b>
<b>БОНХС</b>	<b>Байгаль орчин ногоон хөгжлийн сайд</b>
<b>ЗДТГ</b>	<b>Засаг даргын тамгын газар</b>
<b>ИТХ</b>	<b>Иргэдийн төлөөлөгчдийн хурал</b>
<b>ИТХТ</b>	<b>Иргэдийн төлөөлөгчдийн хурал тэргүүлэгчид</b>
<b>СТСХ</b>	<b>Санхүү төрийн сангийн хэлтэс</b>
<b>БОАЖГ</b>	<b>Байгаль орчин аялал жуулчлалын газар</b>
<b>МХГ</b>	<b>Мэргэжлийн хяналтын газар</b>
<b>УЦУОША</b>	<b>Ус цаг уур орчны шинжилгээний алба</b>
<b>ОХБЦГ</b>	<b>Орхоны хөндийн байгалийн цогцолборт газар</b>
<b>АДБОУС</b>	<b>Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт</b>
<b>БНАТ</b>	<b>Байгалийн нөөц ашигласны төлбөр</b>
<b>ААН</b>	<b>Аж ахуй нэгж</b>
<b>ХХК</b>	<b>Хувьцаат хязгаарлагдмал компани</b>
<b>ОНӨААТУГ</b>	<b>Орон нутгийн өмчтэй аж ахуй тооцоотой үйлдвэрийн газар</b>



## НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь заалтын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2016 оны 1 дүгээр сарын 01 тоот тогтоол, МУ-ын Ерөнхий аудиторт аймгийн Аудитын газраас 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан ҮАГ-НАГ/2016/05-НА/ төлөвлөгөөг үндэслэн Өвөрхангай аймагт Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд аудитыг хийж гүйцэтгэв.

#### 1. Аудитын зорилт:

Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, аймаг, нийслэлийн хэмжээнд мөрдэх шийдвэр, дүрэм, журам баталж биелэлтийг хангуулах үйл ажиллагаа нь Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжид нийцэж буй эсэхэд нийцлийн аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Үүнд:

- Аймгийн ИТХурал, Засаг дарга байгаль орчныг хамгаалах талаар хуульд заасан үүргийг биелүүлсэн эсэх.
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу төлөвлөж бүрэн төвлөрүүлсэн эсэх.
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хуваарилсан хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу зарцуулсан эсэх.
- Байгаль хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг хуульд заасны дагуу хэрэгжүүлсэн эсэх.

#### 2. Аудитын хамрах хүрээ:

Энэхүү аудитыг Өвөрхангай аймгийн ИТХурал, Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын СТСХэлтэс, Засаг даргын дэргэдэх БОАЖГазар, Татварын хэлтэс, МХГазар, Онги Таацын сав газрын захиргаа, Хужирт, Хархорин, Бат-Өлзий, Уянга, Тарат сумдын ИТХурал, Засаг дарга, Байгаль орчны улсын байцаагч, Татварын улсын байцаагч, Төрийн сангийн ажилтнууд болон холбогдох аж ахуйн нэгжүүдийг хамруулан тэдгээрийн ажлын тайлан, статистик мэдээ, судалгааны материалд тулгуурлан аудитыг гүйцэтгэв.

#### 3. Аудитад хэрэглэсэн арга зүй:

Аудитыг АДБОУС 100-400, 4000, 4200, Төрийн хяналт шалгалтын стандартыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр болон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулах ажиллагаа хийгдэв.



#### 4. Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль;
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль;
- Ойн тухай хууль;
- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль;
- Усны тухай хууль;
- Татварын өрөнхий хууль;
- Байгалийн ургамлын тухай хууль;
- Амьтны тухай хууль;
- Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”
- Засгийн газрын 2006 оны 137 дугаар тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагад байгаль орчны мэргэжлийн байгууллагын эрх олгох журам”

#### 5. Аудитын стандартын талаарх мэдэгдэл:

Энэхүү аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын УАГ-НАГ/2016/05-НА/ төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдөж ажиллав. Төрийн хяналт, шалгалтын стандарт, аудитын журамд заасны дагуу аудитын дүгнэлтэд дэмжлэг болох, нотлох зүйлс, холбогдох бусад мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав.

Өвөрхангай аймгийн Аудитын газрын ахлах аудитор Д.Гансүх, аудитор П.Хорлоосүрэн, шинжээч О.Ринчинмядаг нар 2016 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс 10 дугаар сарын 07-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв.

Аудитаар 939791.9 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлээд байна. Энэ нь байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хувь, хэмжээний доод хязгаарыг байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого 15 хувь, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого 50 хувь, ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 85 хувь, ус, ращааны нөөц ашигласны төлбөрийн орлого 35 хувь” гэсэн заалтуудыг зөрчиж байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хувь хэмжээг хуульд зааснаас 2014 онд 2.1-40.1 хувь буюу 134330.8 мянган төгрөг, 2015 онд 0.6-79.0 хувиар буюу 805461.1 мянган төгрөгөөр дутуу тооцсон зөрчил илэрсэн байна.



**Тус аймагт байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хөрөнгийг хуульд заасан хувь хэмжээгээр тооцдоггүй, байгаль орчныг бохирдуулж, доройтуулах зөрчлүүд гарсаар байна.**

**A. Аймгийн ИТХурал болон Засаг даргаас байгаль орчныг хамгаалах талаар хуульд заасан үүргээ хэрэгжүүлж ажилласан ч байгаль орчныг бохирдуулах, доройтуулах зөрчлүүд гарсаар байна.**

**A.2 Аймгийн ИТХурал нь нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөөв баталж, биелэлтэд хяналт тавих бүрэн эрхээ хэрэгжүүлж ирсэн байна.<sup>1</sup>**

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны № 06 тогтоолоор ой бүхий сумдад 2015 онд ойгоос бэлтгэх модны тоо хэмжээг 35200 шоо метрээр, ойн цэвэрлэгээ гүйцэтгэх талбайн хэмжээг 1010 га-аар баталсан бол аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны № 07 тогтоолоор ой бүхий сумдад 2016 онд ойгоос бэлтгэх модны тоо хэмжээг 31200 шоо метр, ойн цэвэрлэгээ гүйцэтгэх талбайн хэмжээг 650 га-аар баталсан байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны № 01 тогтоолоор Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг гар аргаар ашигт малтмал олборлолтын улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, булаг шанд, рашаан, голын эхийг хashiж хамгаалах, мэдээлэл сургалт, сурталчилгаа, байцаагч, байгаль хамгаалагч, нөхөрлөл, ТББ-дад сургалт, сурталчилгаа хийх, ан амьтдыг хамгаалах чиглэлээр байгуулагдсан иргэдийн нөхөрлөлүүдийг чадваржуулах, үйл ажиллагааг дэмжих, ойжуулалт, ойн зуравс , мод үржүүлгийн газарт дэмжлэг үзүүлэх, өмнөх жилийн ойжуулалтын арчилгаа хамгаалах зэрэг нийтдээ 9 арга хэмжээнд 121474.0 мянган төгрөгийг баталсан байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны №15 тогтоолоор байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг Дэлгэрэх голын голдрилыг шулуутгах, булаг шанд, рашаан, голын эхийг хashiж хамгаалах, мэдээлэл сургалт, сурталчилгаа, хяналт шалгалт хийх, байцаагч, байгаль хамгаалагчдыг чадваржуулах, хог хаягдлын менежментийг сайжруулах, Арвайхээр сумын төвлөрсөн хогийн цэгийг хашаалах, ан агууруын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, Арвайхээр сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, ойн хөнөөлт шавжтай тэмцэх зэрэг нийтдээ 8 төрлийн 164902.8 мянган төгрөгийн төсөөв баталжээ.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны № 14 тогтоолоор Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг мэдээлэл сургалт, сурталчилгаа, булаг шанд, рашаан, голын эхийг хashiж хамгаалах, ундны усанд шинжилгээ хийлгэх, газрын

<sup>1</sup> Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх

1. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөөв баталж, биелэлтэд хяналт тавих;

2/ нутаг дэвсгэртээ тухайн жилд ашиглах байгалийн баялгийн нөөцийн дээд хэмжээг энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу тогтоо;

3/ байгаль орчны улсын тусгай хамгаалалтад ороогүй объектыг орон нутгийн хамгаалалтад авах шийдвэр гаргаж, түүний хилийн зааг, хамгаалалтын дэглэм тогтоож, биелэлтэд нь хяналт тавих;

4/ хот, тосгон, бусад суурин болон амралт, сувиллын газар, гол, мөрний эх, нуур, рашаан, булаг, шанд, уст цэгийн орчинг хамгаалах, эрүүл ахуйн шаардлагыг хангах тусгай бүсийн заагийг тогтоох;

5/ байгаль орчны төлөв байдал, мэдээллийн сангийн тухай Засаг даргын мэдээлэл, тайлланг хэлэлцэх.



нөхөн сэргээлт, запуучуудыг чадваржуулах сургалтанд хамруулах, ойн зурvas байгуулах, ойн хөнөөлт шавжтай тэмцэх, Арвайхээр сумын агаарын бохирдлыг бууруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зэрэг нийтдээ 9 арга хэмжээнд 162416.7 мянган төгрөгийг баталсан байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн №06/42 дугаартай хуралдааны тэмдэглэлээр алтны олборлолт хийгдэж буй Бат-Өлзий, Зүүнбаян-Улаан сумдын Засаг дарга нарын тайлан мэдээллийг сонссони зэрэгцээ 2015 оны байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар гүйцэтгэсэн ажлын тайланг аймгийн Засаг даргын дэргэдэх БОНХАЖГазрын дарга Г.Баясгалан танилцуулж, хуралдааны тэмдэглэлээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар гүйцэтгэх ажлыг ойрын хугацаанд хийж дуусгах үүргийг өгсөн байна.

Хархорин, Хужирт, Өлзийт сумдын нутгийг дамнан оршдог Дулаан хайрхан уулыг улсын тусгай хамгаалалтад авах тухай аймгийн ИТХурлаас 2015 онд тогтоол гарган БОНХЯаманд хүргүүлсэн.

Аймгийн газар нутгийн байгалийн унаган төрх, хэв шинжийг хадгалах, ховор, ховордсон ургамал, амьтан, газрын өвөрмөц тогтоц, түүхийн дурсгалт газар түүний орчныг хамгаалах зорилгоор аймгийн Улсын тусгай хамгаалалттай газар, хот тосгоны газар, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй газраас бусад газрыг аймгийн ИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 12/07 дугаар тогтоолоор аймгийн тусгай хамгаалалтад авч, тусгай хамгаалалттай газарт мөрдөх дэглэмийг баталсан байна.

Аудитаар явж ажилласан сумдын ИТХурал болон ИТХТ-ээс баталсан тогтоолоос үзвэл: Бат-Өлзий сумын ИТХТ-ийн хурлаас жил бүр ойн аж ахуйн нэгж, нөхөрлөлүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгсөн, хэрэглээний болон түлшний модны тоо хэмжээ, хуваарийг баталсан, Орчны бүсийн зөвлөл шинэчлэн байгуулсан, Менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг байгуулсан, Байгалийн дагалдах баялаг болох самар түүж бэлтгэх дээд хэмжээг тогтоосон, түүний татварыг төвлөрүүлсэн, Сумын байгаль хамгаалах чиглэлээр хийж байгаа Засаг даргын ажлын тайланг сонссон, байгаль хамгаалах талаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж ажилласан байна.

Тарагт сумын ИТХТ-ийн хурлаас байгаль орчны улсын байцаагчийн элс хайрга ашиглалт, нөхөн сэргээлтийн ажлын тайланг хэлэлцсэн байна.

Уянга сумын ИТХТ-ийн хурлаас хог хаягдлын төлбөрийн хэмжээг тогтоосон, ой хээрийн түймрээс хамгаалах, түймэртэй тэмцэх төлөвлөгөө болон ойгоос ашиглах ойн нөөцийн хуваарийг баталсан, Найман нуурын байгалийн дурсгалт газрыг цогцолбор газрын ангилалд оруулж хамгаалалтын зэргийг нэмэгдүүлэх, сумын ИТХ-ын тэргүүлэгчид, сумын засаг дарга, байгаль орчны ажилтнуудын хамт уул уурхайн нөлөөлөлд орсон газруудаар явж санал дүгнэлт гаргах, гэрээний төсөл боловсруулах, ялангуяа нөхөн сэргээлтийг хийлгүй ор нэр төдий хаяд явсан ААНэгжүүд, иргэдийн асуудлыг газар дээр нь шалгаж хууль хяналтын байгууллагад нэн даруй шилжүүлэх арга хэмжээ авахаар шийдвэрлэсэн, сумын нутаг дэвсгэр дээр хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааг нөхөрлөлийн зохион байгуулалтад шилжүүлэх зэрэг шийдвэр гаргаж ажилласан байна

Хархорин сумын ИТХ-ын тогтоолоор “Дулаанхайрхан, Их эрээн, Шанх нөхөрлөлд байгаль орчныг хамгаалах, эзэмших саналыг зөвшөөрсөн, сумын ИТХТ-ийн хурлаар өрхийн түлээний хэрэгцээнд мод бэлтгэх, Ногоон байгууламжийн ашиглалт, хамгаалалтын журам, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Дулаан хайрхан уулыг Улсын тусгай хамгаалалттай газрын Байгалийн нөөц газраар тогтоолгохоор дэмжин аймгийн ИТХ-д уламжилсан, Байгаль хамгаалах санд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмыг



баталсан, Менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг байгуулж, төлөвлөгөөг баталсан, ОХБЦГ-ын Хархорин сумын орчны бүсийн ажлын тайланг сонссон байна.

Хужирт сумын ИТХ-ын тогтоолоор Рашаан сувиллуудын нэгдсэн цэвэрлэх байгууламж байгуулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулсан, сумын ИТХТ-ийн хурлаар жил бүр нөхөрлөл болон мэргэжлийн байгууллагын хийсэн ажлын тайланг хэлэлцсэн, ойгоос түлээ, хэрэглээний мод бэлтгэх тоо, хэмжээг хуваарилж баталсан, ойн дагалт баялгаас татвар төвлөрүүлэхээр тогтоосон байна.

Аймгийн ИТХурал нь нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ боловсруулж, эрхээ хэрэгжүүлж ирсэн байна

**A.3 Аймгийн Засаг дарга нь нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ боловсруулж, аймгийн ИТХуралд өргөн мэдүүлж, гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулан ажиллаж байгаа ч байгаль орчныг бохирдуулах, доройтуулах зөрчлүүд гарсаар байна.<sup>2</sup>**

БОНХАЖСайд болон аймгийн Засаг даргын хооронд байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуучлалын бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх талаар жил бүр гэрээ байгуулж ажилласан байна. Үүнд:

- 2014 онд Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх 9 арга хэмжээнд 121474.0 мянган төгрөг, Сайдын багцаас ойн зурvas байгуулахад 10 га 20000.0 мянган төгрөг, Дэлгэрэхийн гол дээр хөв байгуулахад 135300.0 мянган төгрөгийн ажил хийгдэхээр гэрээ байгуулсан.
- 2015 онд Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх 9 арга хэмжээнд 164902.8 мянган төгрөг, Сайдын багцаас Өвөрхангай аймагт шилмүүст modoор ойжуулах ажилд 50 га 34750.0 мянган төгрөг, Ойн зурvas байгуулахад 5 га 10000.0 мянган төгрөгийн ажил хийгдэхээр гэрээ байгуулсан.
- 2016 онд “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх 10 арга хэмжээнд 162416.7 мянган төгрөг, Сайдын багцаас Бат-Өлзийн суманд шинэс modoор ойжуулах ажил 40 га-д 27800.0 мянган төгрөгийн ажил хийгдэхээр тус тус гэрээ байгуулан ажиллажээ.

Аймгийн Засаг даргаас жил бүр нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ боловсруулж, аймгийн ИТХуралд

<sup>2</sup> 2. Аймаг, нийслэлийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;  
 2/ нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;  
 3/ байгаль орчны мэдээллийн сангийн мэдээ, баримтыг төрийн захирагааны төв байгууллагад хугацаанд нь ирүүлэх;  
 4/ нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх үйл ажиллагаанд харьялалт харгалзахгүйгээр хяналт тавьж, илэрсан зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоо буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;  
 7/нутаг дэвсгэртээ нөхөрлөлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг баталж, санхүүгийн дэмжлэг үзүүлэх;  
 8/нөхөрлөлийн үйл ажиллагааг нутаг дэвсгэртээ батлагдсан төсвийн хүрээнд дэмжин хөгжүүлэх мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах;  
 9/тухайн жилд нөхөрлөлийн хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаарх тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хэлэлцүүлэх;  
 10/байгалийн нөөцийг төрийн нэрийн өмнөөс хамгаалан, халдашгүй байдлыг нь хангах үргийг тухайн нутаг дэвсгэртээ хариуцах.



өргөн мэдүүлж ирсний зэрэгцээ гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж ажилласан байна.

Аймгийн Засаг даргаас 2014 онд орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэжээ.

- Аймгийн хэмжээнд эвдрэлд орсон нийт 143,6 га талбайд нөхөн сэргээлт хийж, техникийн нөхөн сэргээлт 142.9 га, биологийн нөхөн сэргээлт 0.7 га талбайд хийж гүйцэтгэсэн.
- Бүрд, Өлзийт, Баян-Өндөр сумдын 17 булгийн эхийг хашиж хамгаалсан.
- Байгаль орчныг хамгаалах, иргэдэд экологийн боловсрол олгох чиглэлээр 19 суманд 32 удаагийн сургалт, 10 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж 1350 иргэн хамрагдсан. Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр 26 удаагийн мэдээлэл хийж, зөвлөмж гарын авлага бэлтгэн иргэдэд тараасан.
- Ойжуулалтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, шинэсний тарьцаар Бат-Өлзий сумын Их-буян, Оргил-Аргалант хайрхан ойн нөхөрлөлүүд тус сумын Урд агуйт, Өвтийн Эх нуу зэрэг газрын ойн сангийн 35 га талбайд ойн нөхөн сэргээлт гүйцэтгэж, намрын тооллогоор 78.0-83.0 хувийн амьдралттай хүлээлгэж өгсөн.
- Арвайхээр сумын Гэндэнгийн гудамжны дагуух ногоон байгууламжийн усалгааны системийг сольж шинэчилсэний зэрэгцээ Арвайхээр сумын Соёл амралтын хүрээлэн, Хүүхэд залуучуудын парк болон бусад нийтийн эзэмшлийн ногоон байгууламжид 10 нэр төрлийн 3412 ширхэг мод бут тарьж, намрын тооллогоор тарьц суулгацын амьдралт 75.0 хувьтай ургасан.

Бат-Өлзий сумын Сум дундын Ойн ангийн мод үржүүлгийн газарт өргөтгөл шинэчлэлийн ажил явуулахад дэмжлэг үзүүлсэнээр мод үржүүлгийн газарт үр мөчир, бордоо худалдаж авах, хүлэмж засварлах, хүлэмж болон ил талбайн хөрс шороо бэлтгэж тарьц суулгац ургуулах, түр ажилтан ажиллуулах, услалтын систем засварлах ажлыг гүйцэтгэсэн байна. Үүнд: Мод үржүүлгийн газарт шинэсний 1 настай тарьц 164.5 мянга, 2-3 настай тарьц 268.0 мянга, навчит модны суулгац 15.0 мянга орчмыг тарьж ургуулсан байна.



Улсын төсвөөс 2014 онд санхүүжүүлэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг хийсэн байна.

- “Ногоон хэрэм” хөтөлбөрийн хүрээнд 10 га талбайд ойн зурvas байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, 5 га-д Хархорин сумын “Зулзган ой” хоршоо шалгарч сумын төвийн Онгоцон ухаа багт тариалангийн талбайн хөрс хамгаалах зориулалтаар



3000 ширхэг навчит модны суулгац тариалж, намрын тооллогоор 76.0 хувийн амьдралттай хүлээж авсан.


- Дэлгэрэх гол” төслийн хүрээнд 263.9 сая төгрөгийн өртөгтэй 53732,0 м3 ус хуримтлуулах хүчин чадалтай эхний хөвийг хийж гүйцэтгэсэнээр үерийн эрчмийг бууруулж, Дэлгэрэх голын тэжээгдлийг нэмэгдүүлсэн байна.

Бүх нийтээр мод тарих өдрийг аймгийн хэмжээнд 2 удаа зохион байгуулж 215 байгууллага, аж ахуйн нэгжийн 6177 хүн 42388 ширхэг мод, бут сөөг тарьсан байна.

Аймгийн Засаг даргаас 2015 онд орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хүрээнд дараах ажлыг гүйцэтгэсэн байна. Үүнд:

- “Дэлгэрэх гол” төслийн хүрээнд хийгдэх 2 дахь хөвийн зураг төсвийг батлуулж, Арвайхээр сумын 7 дугаар баг руу тус голыг хөндлөн гарах төмөр бетон гүүрийг шинээр тавьж, уг гүүрнээс захын баруун талын засмал замын гүүр хүртэлх 260 метр газарт голын голдрилыг шулуутгах ажлыг “Өндөр сант хайрхан” ХХКомпаниар гүйцэтгүүлсэн.
- Баян-Өндөр, Богд, Хайрхандулаан сумдын 7 булгийн эхийг хашиж хамгаалсан.
- Байгаль орчны багц хууль болон байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр гарсан дүрэм журмыг олон нийтэд сурталчлах, иргэд, өсвер үеийнхний байгаль орчны боловсрол, мэдлэг, чадварыг дээшлүүлэх чиглэлээр 11 суманд мэргэжилтнүүд очиж 16 удаагийн сургалт, 5 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж, түүнд 440 иргэн хамрагдсан. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр 5 төрлийн 3000 гаруй зөвлөмжийг бэлтгэж иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад хүргүүлжээ. Сумдын БОХУБайцаагч, байгаль хамгаалагчдыг чадавхжуулах сургалт семинарыг зохион байгуулсан байна.
- Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулж, “Хог хаягдлын талаарх хууль эрх зүй, дүрэм журам, стандарт, аргачлал” сэдэвт сургалтыг сумдын Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нарт зохион байгуулсан.
- Төв суурин газрын хог хаягдлын жишиг норматив, төлбөрийн хэмжээг аймгийн ИТХ-ын 2015 оны 08 дугаар тогтоолоор шинэчлэн батлуулж, сумдууд хог хаягдлын хураамжийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулсан.
- Арвайхээр сумын төвлөрсөн хогийн цэгт хамгаалалтын хайс барих ажлын гүйцэтгэгчээр “Арвайхээр-Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ыг сонгон 14.5 сая төгрөгөөр гүйцэтгүүлсэн.
- Аймгийн Ан агнуурын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд Богд сумын Сэргээн хайрхан, Хар толгой, Уянга сумын Шар нохойт, Шовх хайрхан зэрэг газруудад байршин нутагшиж буй аргаль янгирт, Есөнзүйл сумын нутаг Дөлгөөн хайрхан, Сэргүүн булаг зэрэг газруудад байгаа халиун буганд хужир, шүү тавьж биотехникийн арга хэмжээ авсан. Ан агнуурын менежмент төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах уулзالت зөвлөгөөнийг зохион байгуулсан.
- Арвайхээр сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээг Арвайхээр сумын Хотын захирагчийн ажлын албатай байгуулан Занабазарын нэрэмжит Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнд 5627 мод бут тарьж 93.0 хувийн амьдралттай, Т.Намнансүрэн, П.Гэндэнгийн нэрэмжит гудамж, Наадмын талбайг зүлэгжүүлэх ажлыг 7800 м2 талбайд гүйцэтгүүлсэн.

Ойн санд тархсан хөнөөлт шавжтай үүргийн шүршигчээр тэмцэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, УБ хотын “Мон таксаци” компаниар гүйцэтгүүлсэн. Устгал тэмцлийн ажлыг Бат-Өлзий, Хужирт, Зүүнбаян-Улаан, Хархорин сумдын ойн санд улсын төсвөөр 5670 га, орон нутгийн төсвөөр 2000 га талбайд утаат үүргийн шүршигч багаж ашиглан химиийн аргаар гүйцэтгэжээ.



Улсын төсвөөс 2015 онд санхүүжүүлэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг хийсэн байна.

- Ойжуулалт, ойг нөхөн сэргээх ажлын хүрээнд шинэсний тарьцаар гүйцэтгэх 50 га ойжуулалтын ажлын гүйцэтгэгчээр Бат-Өлзий сумын “Хонгор” нөхөрлөл 15 га, “Сумт” нөхөрлөл 20 га, “Зээст хайрхан” нөхөрлөл-15 га-д гүйцэтгүүлж, намрын тооллогоор ойжуулалт гүйцэтгэсэн нөхөрлөлүүд 75.0-80.0 хувийн амьдралттай хүлээлгэж өгсөн .
- “Ногоон хэрэм” хөтөлбөрийн хүрээнд 5 га ойн зурvas байгуулах ажлын гүйцэтгэгчээр Хархорин сумын “Насаа нэм” нөхөрлөл шалгаран гүйцэтгэсэн ба гүйцэтгэл намрын тооллогоор 50.0 хувьтай гарчээ.

2015 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 63 дугаар зарлиг, “Нэг сая мод ургуулах хөдөлгөөн зохион байгуулах тухай БОНХАЖСайдын А-146 дугаар тушаал, “Дөчин мянган мод ургуулах хөдөлгөөн зохион байгуулах тухай” аймгийн Засаг даргын 2015 оны а/148 дугаар захирамж гаргуулж, аймгийн хэмжээнд хавар, намрын мод тарих өдрийн арга хэмжээнд нийт 427 аж ахуйн нэгж, байгууллага, 11567 иргэн оролцож 16125 ширхэг мод, 40928 ширхэг бут сөөг буюу нийт 57053 ширхэг мод бут тарьж 12500 м<sup>2</sup> зүлэгжүүлэлт, 5400 м<sup>2</sup> цэцгийн мандал байгуулсан байна.





Тус аймагт 2016 онд ойжуулалт, ойг нөхөн сэргээх, “Ногоон хэрэм” хөтөлбөрийн хүрээнд ойн зурvas байгуулахаар улсын төсвөөр шинэсний тарьцаар гүйцэтгэх 40 га ойжуулалтын ажил, орон нутгийн төсвөөр 5 га ойн зурvas байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, шинэсний тарьцаар гүйцэтгэх 40 га ойжуулалтын ажлын гүйцэтгэгчээр Бат-Өлзий сумын “Гэрэлт түшиг” ХХК 15 га, Сүүндалай трэвлэл ХХК 10 га, Хужирт сумын “Өгөөмөр шунхлай” ХХК-15 га, ойн зурvasын ажлын гүйцэтгэгчээр “Гэрэлт түшиг” ХХК шалгарч гүйцэтгэсэн.

Аймгийн хэмжээнд Бүх нийтээр мод тарих өдрийн арга хэмжээнд нийт 144 аж ахуйн нэгж, байгууллага, 2189 иргэн оролцож 6057 ширхэг мод, 22113 ширхэг бут сөөг буюу нийт 28170 ширхэг мод бут тарьсан байна.



Ойн хөнөөлт шавжтай тэмцэх устгал тэмцлийн ажлыг УБ хотын “Мон таксаци” компани шалгаран Бат-Өлзий, Хужирт, Зүүнбаян-Улаан, Хархорин сумдын ойн санд орон нутгийн төсвөөр 5060 га талбайд утаат үүргийн шүршигч багаж ашиглан химиин аргаар гүйцэтгэсэн байна.

Аймгийн хэмжээнд байгаль хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр 18 төрийн бус байгууллага, 56 иргэдийн нөхөрлөл, 32 малчны бүлэг үйл ажиллагаагаа явуулж байна.

2015 онд ойн зөрчил 48-ыг илрүүлж, захиргааны хэрэг 31, эрүүгийн хэрэг 12 үүсгэн шалгаж, торгууль 29760.6 мянган төгрөг, нөхөн төлбөрт 18798,1 мянган төгрөгийг оногдуулж байсан бол 2016 онд ойн зөрчил 33-ыг илрүүлж ойн зөрчилд захиргааны хэрэг 18, эрүүгийн хэрэг 6 үүсгэн шалгаж, торгууль 18240.0 мянган төгрөг, нөхөн төлбөрт 17259.7 мянган төгрөгийг оногдуулсан байна.

Байгаль хамгаалах иргэдийн нөхөрлөлүүд үйл ажиллагаагаа явуулсанаар байгаль орчин ойн сан эзэнтэй болж, байгаль хамгаалахад нутгийн иргэдийн үүрэг оролцоо сайжирч, ой хээрийн түймэр, хууль бус мод бэлтгэл, ойн зөрчлийн хэмжээ жилээс жилд буурч ирсэн байна.

Гэвч байгаль орчинтой холбоотой зөрчлүүд тодорхой хэмжээгээр гарсаар байгааг аймгийн БОАЖГазар, МХГазар, аймаг, сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч нарын ажлын тайлан, тавьсан акт, албан шаардлагаас хараахад аймаг, сумдын Засаг дарга нар болон холбогдох хяналтын байгууллага, ажилтнууд хяналт шалгалтын ажлаа эрчимжүүлж ажиллах шаардлагатай байна.



Байгаль орчин бохирдож, сүйтгэгдэж байгаагийн нэг тод жишээ бол сүүлийн үед олны анхаарлыг татаж буй Орхон голын бохирдлын асуудал юм.

Орхон голын бохирдлын гол шалтгаан нь Архангай аймгийн Цэнхэр сумын нутаг болох Их Тээлийн гол, Шийртийн голууд Орхон голын эхэд нийлдэг байна. Их Тээл, Шийртийн голын дагуу алтны уурхайнууд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тухайн аж ахуйн нэгжүүд нь эргэлтийн усан сангүй, хаягдлын далангүй, далангууд нь сэтэрсэн, нөхөн сэргээлт хийдэггүйгээс болж Орхон гол бохирдсон байна.

Мөн Монгол улсын Засгийн газрын 2015 оны 7 дугаар сарын 7-ны №289 тогтоолоор “Монгол улсын нутаг дэвсгэр дэх гол, мөрний урсац бүрэлдэх эхийн хилийн зааг”-ийн солбицол, “Ойн сан бүхий газрын хилийн зааг”-ийн солбицолд тус тус өөрчлөлт оруулсанаас Орхон голын сав дагуу үйл ажиллагаа явуулж байгаа алтны уурхайн аж ахуйн нэгжүүд голын эх дагуу газар түрж орон үйл ажиллагаа явуулсанаас голын бохирдол эрс нэмэгдсэн байна.

Орхон голын сав дагуу орших Хархорин, Бат-Өлзийн сумдын 10 гаруй малчидтай уулзаж ярилцахад: голын усыг ундандаа хэрэглэх боломжгүй болсон, ундын усаа сумын төв болон ойр орчмын жижиг гол, горхи, худгаас авч хэрэглэж байгаа, цаашид уг голын усыг мал ч уухад хүндрэлтэй хэцүү байгаа талаар ярьцааж байсан юм.

Аудитаар Орхон голын бохирдлын байдлыг газар дээр очиж үзэхэд шаргал ёнгөтэйгээр урсаж байна.



Бат-Өлзий сумын нутагт-Орхон гол



Orkhon голын усыг цэнгээ голын устай харьцуулахад



Өвөрхангай аймгийн УЦУОШАлбаны лабораторын шинжилгээний дүнгээс үзэхэд Орхон голын усны чанарыг Орхон-Бат-Өлзий, Орхон-Улаан цутгалан харуул орчим 8 дугаар сарын 19-21-нд дээж авч шинжилгээ хийхэд аммони агууламж 1.2-4.6 дахин, нитритийн агууламж 0.8-7.6 дахин, фосфортын агууламж 2.0-6.0 дахин давсан гэсэн үзүүлэлт гаргасан байна. Усны бохирдлын индекс 3 дугаар зэрэг буюу бохирдолтой гэсэн ангилалд орсон байна.



Тиймээс байгаль орчноо хамгаалах талаар төрийн эрх барих дээд байгууллага болох УИХ, Засгийн газраас эхлээд хууль, тогтоомжоо боловсронгуй болгох, аймаг, сумдын Засаг дарга нар хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

**БОНХАЖСайд** болон аймгийн Засаг даргын хооронд байгуулсан 2015 оны гэрээний биелэлтийг дүгнэсэн ажлын хэсгийн үнэлгээгээр Өвөрхангай аймаг гэрээнд тусгагдсан нийт арга хэмжээ 21 ба тасарсан арга хэмжээ байхгүй 82.7 хувиар үнэлгэдсэн байна.

Тус аймагт Онги-Таац голын сав газрын захиргаа ажилладаг бөгөөд сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх, Улсын усны мэдээллийн санг бүрдүүлэх, Усны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Гол мөрөн, нуур усны эх үүсвэр болон газрын доорх цэнгэг усны орд газрыг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах үндэслэлийг боловсруулах, Сав газрын хэмжээнд ашиглагдах боломжит усны нөөц, ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавих, Усны барилга байгууламж, ус ашиглалтын асуудлуудыг хариуцан Өвөрхангай аймгийн 11 сум, Баянхонгор аймгийн 2 сум, Өмнөговь аймгийн 7 сум, Дундговь аймгийн 2 сум, нийтдээ 4 аймгийн 22 сумын нутаг дэвсгэрийг хамарсан 64443 м<sup>2</sup> талбайг хариуцан ажилладаг байна.

Онги-Таац голын сав газрын захиргаанаас дараах ажлыг зохион байгуулан ажилласан байна. Үүнд:

- Байгаль хамгаалах хуулийг хангуулах ажлын хүрээнд аймгийн Засаг даргын а/346, а/365 тоот захирамжийг гаргуулж ажилласан.
- “Бөөрөлжүүт”-ийн голд хууль бус үйл ажиллагаа явуулсан иргэн, аж ахуйн нэгжийн нийт 13 этгээдэд хохирол тооцон аймгийн Засаг дарга, ИТХ-ын даргад танилцуулсан ба тусгай зөвшөөрөлгүй, хууль бусаар олборлолт явуулсан “Арвайн-Уянга”ХХК, “Сэнгиг-Адир” ХХК, “БМБП” ХХК, иргэн Алтанцэцэг нарыг аймгийн Цагдаагийн байгууллагад хандан хэрэг бүртгэл явуулсан.
- Онги голын онцгой хамгаалтын бүсийг тэмдэгжүүлэх ажлыг зохион байгуулах тухай саналыг Уянга, Зүүнбаян-Улаан, Нарийнтээл сумдад хүргүүлэн хэрэгжилтийг зохион байгуулсан.
- Аймгийн БОАЖГ-тай хамтран аймгийн хэмжээнд Усны эх үүсвэрийн хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулж, сумдын ойролцоо гол горхи, булаг, нуур, худгуудын ойр орчмын 243 га талбайг цэвэрлэж, нийтдээ 1422 иргэдийн оролцоотойгоор 85 тн хог хаягдлыг цэвэрлэсэн байна.

Аудитаар ажилласан сумдаас үзэхэд: Уянга сумын Засаг даргын захирамжаар Хуш модны самрын түүлгэх хугацааг тогтоосон, сумын нийтийн эзэмшлийн газрын хог хаягдлыг цэвэрлүүлэх, хяналт тавих ажлын хэсгийг байгуулсан байна.

Хархорин сумын Засаг даргын захирамжаар түлшний хэрэгцээг түлээнийн захын хашаанаас нэгдсэн журмаар зарж, борлуулах ажлыг зохион байгуулах, Байгаль орчин, ногоон хөгжлийн зөвлөлийг орон тооны бус хэлбэрээр байгуулж, дүрэм, ажиллах журам, үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан, Элс, хайрга ашиглуулах журам, эрхийн бичгийн загварыг баталсан, Төвлөрсөн усан хангамжийн хамгаалалтын бүсийг тогтоосон, 5 болон 10 сард нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулах, Орхон багийн нутаг дэвсгэрт 600 га талбайд ойн хортон шавьж устгалын ажлыг зохион байгуулах, мөн Орхон, Шанх багийн нутаг дэвсгэрт 1000 га талбайд ойн хортон шавьж устгалын ажлыг зохион байгуулах шийдвэр гарган хэрэгжилтийг зохион байгуулжээ.

Аймгийн Засаг даргаас нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр боловсруулан



аймгийн ИТХуралд өргөн мэдүүлсэн бөгөөд хурлаас гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулж ажиллаж байгаа боловч байгаль орчныг бохирдуулах, доройтуулах, сүйтгэх зөрчлүүд тодорхой хэмжээгээр гарсаар байна.

### **Зөвлөмж: Аймгийн Засаг дарга Г.Ганболдод**

- *Байгаль орчныг хамгаалах талаар хуульд заасан бүрэн эрхээ бүрэн хэрэгжүүлж, байгаль орчинд тавих хяналтаа сайжруулах.*
- *Орхон голын эхэнд холбогдох зөвшөөрөлгүй, хууль бус үйл ажиллагаа явуулж байгаа алтны уурхайнуудын үйл ажиллагааг зогсоох, тусгай зөвшөөрлийг цуцлах, аж ахуйн нэгжүүдийн байгаль орчинд учруулсан хохирлыг арилгуулах, нөхөн сэргээлт хийлгэх талаар холбогдох шатны байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх.*

**Б. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу төлөвлөсөн ч төлөвлөлтийн үндэслэл бодитой биш, орлогын гүйцэтгэл төлөвлөснөөс 3.6-4.1 хувиар тасарсан байна.**

#### **Б.1 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлтийн үндэслэл бодитой биш байна.**

БОНХС-ын 2014 оны №А-258, 2015 оны №А-268 тушаалаар баталсан “Байгалийн ургамал ашиглах дээд хэмжээг тогтоох тухай” шийдвэрт Өвөрхангай аймгаас ургамал ашиглах тухай тусгагдаагүй байна.

БОНХС-ын 2014 оны №А-128 тушаал, №А-426 тушаал, БОНХАЖС-ын 2015 оны №А-214, №А-446 тушаалаар баталсан “Тусгай болон ахуйн зориулалтаар амьтан агнах, барих хуваарь батлах тухай” шийдвэрээр ан амьтны тоо хэмжээ, хуваарийг аймаг, сумдаар баталж, амьтны нөөц ашигласны төлбөрийн 50.0 хувийг тухайн агнуурын бус нутгийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зарцуулах, агнуурын бус нутгийн менежментийг хариуцагч иргэн, хуулийн этгээдийн оролцоог хангах, хууль бус агнуураас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулахыг аймгийн Засаг дарга наарт үүрэг болгосон байна.

БОНХС-ын 2014 оны №А-06, №А-382 тушаал, БОНХАЖС-ын 2015 оны №А-415 тоот тушаалаар баталсан “Ойгоос бэлтгэх модны дээд хязгаар батлах тухай” шийдвэрээр аймаг, сумдад бэлтгэх модны тоо хэмжээ, хуваарийг баталж, ойгоос бэлтгэсэн модны 100 шоо метр тутамд өөрийн хөрөнгөөр 3 га талбайд ой тарьж ургуулах, БОНХАЖС-ын 2015 оны №А-415 тушаалаар үйлдвэрлэлийн отглолтоор бэлтгэсэн 100 шоо метр мод тутамд 1.5 га, арчилгааны сийрүүлэх болон завсрын цэвэрлэгээний отглолтоор бэлтгэсэн хэрэглээний модны 100 шоо метр тутамд холбогдох аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгөөр 1.5 га талбайд ойжуулалт хийлгэх, уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор ойгоос мод бэлтгэсэн иргэнээр Ойн тухай хуулийн отолсон 1 модны оронд 10 мод ойд тарьж ургуулах заалтын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг хамтран зохион байгуулахыг аймгийн БОАЖГазар, сумдын Засаг дарга, Ойн анги, Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны дарга, МХГазрын дарга наарт даалгажээ.

БОАЖС-ын 2016 оны №А-17 тушаалаар баталсан “Хуш модны самар түүж бэлтгэх тухай” шийдвэрт Хуш модны самрыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх аймаг сумдад Өвөрхангай аймгийн Бат-Өлзий, Хужирт сум, Хуш модны самрыг ахуйн зориулалтаар түүж бэлтгэх аймаг, сум, Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын



захиргаадад тус аймгийн Хархорин, Уянга, Зүүнбаян-Улаан сум, ОХБЦГазрыг тус тус зөвшөөрсөн байна.

БОНХАЖС-ын 2015 оны №А-338 тушаалаар баталсан “Ойгоос хуш модны самар түүж бэлтгэх, хориглох тухай” шийдвэрт самрыг 2015 оны 10 дугаар сарын 01-ээс бэлтгэх. Хуш модны самрыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх аймаг сумдад Бат-Өлзий сум, Хуш модны самрыг ахуйн зориулалтаар түүж бэлтгэх аймаг, сум, Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаадад Бат-Өлзий, Хужирт, Уянга, Зүүнбаян-Улаан сумдад зөвшөөрсөн байна. Харин самрын ургац маш муу болон муу байгаа Хархорин суманд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэхийг хориглосон байна.

Дээрх БОНХАЖСайдын шийдвэр болон урд онуудын байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэлийг үндэслэн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөж ирсэн байна. (Хүснэгт 01-с харна уу).

#### **Байгалийн нөөц ашигласаны төлбөрийн орлогын 2014-2016 оны төлөвлөлт**

Хүснэгт-01		/мянган төгрөг/		
Д.д	Байгалийн нөөц ашигласны төлбөр	2014 оны төлөвлөгөө	2015 оны төлөвлөгөө	2016 оны төлөвлөгөө
1	Агнуурын нөөц ашигласны төлбөр	76522.2	329472.5	100504.0
2	Рашаан, ус ашигласны төлбөр	368652.5	340160.4	303900.0
3	Ойгоос мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	112225	835843.6	139290.0
4	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	0	0	0
Дүн		557399.7	1505476.5	543694.0

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын сүүлийн 3 жилийн төлөвлөлт гүйцэтгэлээс үзэхэд зөрүү хэлбэлзэл 4.0 орчим хувьтай байгаа, жил бүр байгалийн дагалдах баялаг болох самрын орлогоор тодотгол хийгдэж байгаа зэргээс үзэхэд төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах шаардлагатай байна.

#### **Б.2 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэл сүүлийн 3 жилийн байдлаар 95.9-96.4 хувийн биелэлттэй буюу төлөвлөснөөс 3.6-4.1 хувиар тасарсан үзүүлэлттэй гарсан байна.**

Тус аймагт байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэлийг сүүлийн 3 жилээр авч үзвэл дараах байдалтай байна. (Хүснэгт 02-с харна уу).



## 2014-2016 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэл

Хүснэгт-02

/мянган төгрөг/

Д д	Нөөцийн төлбөрийн төрөл	2014 он			2015 он			2016 он		
		Төл	Гүйц	Зөрүү	Төл	Гүйц	Зөрүү	Төл	Гүйц	Зөрүү
1	Агнуурын нөөц ашигласны төлбөр	76522.2	71922.2	-4600	329472.5	336657.2	7184.7		21142.2	21142.2
2	Рашаан, ус ашигласны төлбөр	368652.5	346618.8	-22033.7	340160.4	290968.2	-49192.2	24250	29206.3	4956.3
3	Ойгоос мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	112225	115914.3	3689.3	835843.6	823759.5	-12084.1	13381.2	20666.8	7285.6
4	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	-	-	-	-	-	-	-	-	-
	Дүн	557399.7	534455.3	-22944.4	1505477	1451385	-54091.6	37631.2	71015.3	33384.1

Дээрх хүснэгтээс харвал байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэл 95.9-96.4 хувийн биелэлттэй буюу төлөвлөснөөс 3.6-4.1 хувиар тасарсан үзүүлэлттэй гарсан байна.

2015 онд ойгоос мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогоор 823759.5 мянган төгрөгийг төсөвт оруулсаны 78100.0 мянган төгрөг нь мод түлээ бэлтгэж ашигласны, 745659.5 мянган төгрөг нь ойн дагалт баялаг /самар/ ашигласны төлбөрийн орлого байна.

Дээрхи хүснэгтийг ашиглан графикаар харуулбал:

График-01





График-02



График-03



Усны тухай хуулиар ус хэрэглэгч байгууллага, аж ахуйн нэгжүүд холбогдох байгууллагаас дүгнэлт, зөвшөөрөл авсны үндсэн дээр тухайн шатны Засаг дарга гэрээ байгуулж, төлбөрийн хэмжээг шоометр тутамд ногдуулж авахаар тогтоосон байдаг боловч энэ нь орон нутагт хэрэгжилт хангалтгүй байна.

Энэ нь БОНХАЖС-ын 2015 оны 08 дугаар сарын 05-ны №А-323 тушаал “Ус ашиглаулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлсийг шинэчлэн батлах тухай” шийдвэрээр аж ахуйн нэгж, байгууллагын ус ашиглаулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлсийг 50 хүртэл шоо метр/хоногт 360.0 мянган төгрөг, 50-100 шоо метр/хоногт 490.0 мянган төгрөг гэх мэтээр 3000.0 дээш шоометр/хоногт усны нөөц ашигласанд оногдуулсан төлбөрийн хэмжээнээс 1.0 хувиар тооцохоор заажээ.

Энэ шийдвэрээр ус ашиглаулах дүгнэлтийн хөлс өндөр тогтоогдсон болон орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагуудын төлбөрийн чадвар муу байгаагаас дүгнэлтээ гаргуулж чадахгүй байдал нийтлэг байна.

Аудитаар явсан сумдуудад ус ашиглагч аж ахуйн нэгж, байгууллагууд ус ашиглах дүгнэлтээ гаргуулаагүй, гэрээ байгуулаагүйгээс ус ашигласны төлбөрийг өмнөх оны төлөлтийн жишгээр тооцож ирсэн байна.

#### Зөвлөмж: Аймгийн Засаг дарга Г.Ганболдод

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах.
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоо орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлж, хэлтэс албадын ажлын уялдаа холбоог хангаж ажиллах.



- БОНХАЖС-ЫН 2015 ОНЫ №А-323 ТУШААЛААР БАТАЛСАН “УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ ГАРГАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСИЙГ ТОГТООСОН ХЭМЖЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЖИХ НӨХЦӨЛ БОЛОМЖИЙГ СУДЛАН ХӨЛСИЙГ БАГАСГАХ ТАЛААР ХҮСЭЛТ, САНАЛАА ТУС ЯАМАНД ХҮРГҮҮЛЖ, ШИЙДВЭРЛҮҮЛЭХ.

**В. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хуваарилсан хөрөнгө хуульд зааснаас доогуур хувиар тооцсон ч хуваарилсан хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу зарцуулсан байна.**

**В.1 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд эарцуулах хувь хэмжээг хуульд зааснаас 2014 онд 2.1-40.1 хувь, 2015 онд 0.6-79.0 хувиар тус тус доогуур тооцсон байна.<sup>3</sup>**

Тус аймагт 2014 онд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хувь хэмжээг ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос 82.9 хувиар, ус рашааны нөөц ашигласны орлогоос 5.3 хувиар, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоос 9.9 хувиар тус тус тооцсон нь хуулиар тогтоосон доод хувь хэмжээнээс 2.1-40.1 хувь доогуур байна. (Хүснэгт 03-с харна уу)

**2014 онд байгалийн нөөц ашигласны төлбөрөөс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийн тооцоо**

**Хүснэгт-03**

**/мянган төгрөг/**

№	Үзүүлэлт	Байгалийн ургамал ашигласны төлбөр /30%/	Ойн нөөц ашигласны төлбөр /85%/	Ус, рашааны нөөц ашигласны орлого/35%/	Ан амьттаны нөөц ашигласны орлого /50%/	Дүн
1	БНАТөлбөрийн дүн	-	115914.3	346618.8	71922.2	<b>534455.3</b>
2	Нөхөн сэргээхэд зарцуулбал зохих	-	98527.155	121316.58	35961.1	<b>255804.84</b>
3	Зарцуулсан	-	96074.7	18249.7	7149.7	<b>121474.07</b>
4	Хувь	-	97.5	15.0	19.9	47.5

<sup>3</sup> 18 дугаар зүйл. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн хувь, хэмжээ

18.1. Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно:

Байгалийн баялгийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төрөл	Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хувь, хэмжээний доод хязгаар /нийт орлогын дүнгээс хувиар/
1. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого	15 хувь
2. Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	50 хувь
3. Газрын нөөцийн төлбөрийн орлого	15 хувь
4. Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого	85 хувь
5. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	35 хувь



	Нөөцийн төлбөрөөс нөхөн тооцсон хувь	-	82.9	5.3	9.9	
--	---	---	------	-----	-----	--

Аймгийн хэмжээнд 2015 онд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хувь хэмжээг ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос 6.0 хувиар, Ус, рашааны нөөц ашигласны орлогоос 34.4 хувиар, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоос 4.5 хувиар тус тус тооцсон нь хуулиар тогтоосон хувь хэмжээнээс 0.6-79.0 хувиар доогуур байна. (Хүснэгт 04-с харна уу)

**2015 онд байгалийн нөөц ашигласны төлбөрөөс байгаль орчныг хамгаалах,  
нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийн тооцоо**

Хүснэгт-04

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Байгалийн ургамал ашигласны төлбөр /30%/	Ойн нөөц ашигласны төлбөр /85%/	Ус, рашааны нөөц ашигласны орлого/35%/	Ан амьтаны нөөц ашиласны орлого /50%/	Дүн
1	БНАТөлбөрийн дүн	-	823759.5	290968.2	336657.2	1451384.9
2	Нөхөн сэргээхэд зарцуулбал зохих	-	700195.6	101838.9	168328.6	970363.05
3	Зарцуулсан	-	49507.3	100197.3	15197.3	164901.93
4	Хувь	-	7.1	98.4	9.0	17.0
	Нөөцийн төлбөрөөс нөхөн тооцсон хувь	-	6.0	34.4	4.5	

Аудитаар явж ажилласан Хужирт, Хархорин, Бат-Өлзий, Уянга, Тарагт сумдад байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хөрөнгө зарцуулаагүй байна.

**Зөвлөмж: Аймгийн Засаг дарга Г.Ганболдод**

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь хэмжээг хуульд заасан доод хэмжээнээс бууруулахгүйгээр төлөвлөн аймгийн ИТХ-аас батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах.

**В.2 Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээний доод хязгаараас 2.1-79.0 хувиар доогуур тооцож, Засгийн газрын 2014 оны 43 дугаар тоогоолоор батлагдсан журмын 3.3-т заасан арга хэмжээний хүрээнд зарцуулсан байна.<sup>4</sup>**

<sup>4</sup> 3.3. Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийг Засгийн газрын 2014 оны 43 дугаар тоогоолоор батлагдсан журмын 2.2.4-т заасныг үндэслэн:

3.3.1. аимаг болон тухайн сумын ой зохион байгуулалт хийх, ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх арга хэмжээ авах, нөхөрлөл, ойн анги, ойн мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийг дэмжих;

3.3.2. ойн хөнөөлт шавж, өвчний хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, суурин судалгаа хийх;

3.3.3. ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, унтраах;

3.3.4. ойн үр бэлтгэх ой сонгох, плантаци байгуулах, үр, боргоцой бэлтгэх боловсруулах, тарьц, суулгац ургуулах, ойг нөхөн сэргээх, тарьж ургуулах, байгалийн сэргэн ургалтад туслах, ойн зуравс, модлог ургамлын цэцэрлэг байгуулах, голын эх, эрэг



Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос 2014 онд 82.9 хувь, 2015 онд 6.0 хувиар тус тооцсон нь байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хуульд заасан хувь хэмжээний доод хязгаараас 2.1-79.0 хувиар доогур тооцсон байна.

Мөн 2014 онд ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний дараах зүйлд зарцуулсан байна. Үүнд:

- Гар аргаар ашигт матмал олборлолтын улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтэд 25 га-д 45000.0 мянган төгрөг
- Ойжуулалт 35 га-д 24325.0 мянган төгрөг
- Ойн зурvas /Арвайхээр суманд ногоон байгууламж/ 7.5 га-д 15000.0 мянган төгрөг
- Мод үржүүлгийн газарт дэмжлэг үзүүлэх – 3000.0 мянган төгрөг
- Өмнөх жилийн ойжуулалтын арчилгаа хамгаалах – 50 га –д 4000.0 мянган төгрөг
- Сургалт сурталчилгаанд 4749.7 мянган төгрөгийг тус тус зарцуулсан нь Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.3-т заасан арга хэмжээний хүрээнд зарцуулсан байна.

2015 онд ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний дараах зүйлд зарцуулсан байна. Үүнд:

- Арвайхээр сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд 16950.0 мянган төгрөг
- Ойн хөнөөлт шавжтай тэмцэхэд 400 га-д 19360.0 мянган төгрөг
- Мэдээлэл, сургалт сурталчилгаа, хяналтад 13197.3 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

2016 онд ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд дараах зүйлд зарцуулахаар төлөвлөсөн байна. Үүнд:

- Газрын нөхөн сэргээлтэд 18 га-д 20000.0 мянган төгрөг
- Ойн зурvas байгуулахад 5 га-д 10000.0 мянган төгрөг
- Ойн хөнөөлт шавжтай тэмцэхэд 5000 га-д 45000.0 мянган төгрөг
- Арвайхээр сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд 21916.7 мянган төгрөг
- Мэдээлэл, сургалт сурталчилгаа, хяналтад 15000.0 мянган төгрөгийг тус тус хуваарилсан нь холбогдох журмын дагуу зарцуулагдаж байна.

**B.3 Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээний доод хязгаараас 0.6-29.7 хувиар доогуур тооцсон боловч Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.2-т заасан арга хэмжээний хүрээнд зарцуулсан байна.<sup>5</sup>**

дагуу мод тарьж төгөл байгуулах, баянбүрд бий болгох, хууль бус мод бэлтгэх зэрчлийг бууруулах, хяналт шалгалац хийх арга хэмжээнд тус тус зарцуулна.

<sup>5</sup> 3.2. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийг энэхүү журмын 2.2.3-т заасныг үндэслэн:

3.2.1. усны сав газарт усны нөөцийн хайгуул судалгаа, зураглал хийх, усны нөөц, горим, чанарын төлөв байдал, өөрчлөлтөд хяналт-шинжилгээ явуулах, усны тоо бүртгэл хийх;

3.2.2. усны үр ашигтай, хэмнэлттэй хэрэглээг болон хаягдал усиг дэвшилтэт технологиор цэвэрлэх, тоолууржуулах, унд-ахуйн ус хангамж, ариутах татуургын байгууламжийг шинэчлэх, засч сэлбэхийг дэмжих, ундны ус цэнгэгкүүлэх, усны хяналт шинжилгээний болон лабораторийн тоног төхөөрөмж худалдан авах, хаягдал ус зайлцуулах цэгийг сайжруулах;

3.2.3. Усны тухай хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, дүрэм журмыг мөрдүүлэх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн заагийг тэмдэгжүүлэх, хаалт, хамгаалалт хийх, тохижуулах;

3.2.4. усны сав газрын усны нөөцийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, усны сав газрын зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих, орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх;



Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоос 2014 онд 5.3 хувь, 2015 онд 34.4 хувиар тус тооцсон нь байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хуульд заасан хувь хэмжээний доод хязгаараас 0.6-29.7 хувиар доогуур тооцсон байна.

Мөн 2014 онд ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд дараах зүйлд зарцуулсан байна. Үүнд:

- Булаг шанд, рашаан, голын эхийг хашиж хамгаалахад 9 булаг 13500.0 мянган төгрөг
- Мэдээлэл, сургалт сурталчилгаанд 4749.7 мянган төгрөгийг зарцуулсан.

2015 онд ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд дараах зүйлд зарцуулсан байна. Үүнд:

- Дэлгэрэх голын голдрилыг шулуутгахад 75000.0 мянган төгрөг
- Булаг шанд, рашаан, голын эхийг хашиж хамгаалахад 7 булаг 12000.0 мянган төгрөг
- Мэдээлэл, сургалт сурталчилгаа, хяналтад 13197.3 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.

2016 онд ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд дараах зүйлд зарцуулахаар төлөвлөсөн байна. Үүнд:

- Булаг шанд, рашаан, голын эхийг хашиж хамгаалахад 10 төрлийн 18000.0 мянган төгрөг
- Ундны усанд шинжилгээ хийлгэхэд 28 төрлийн 2500.0 мянган төгрөг
- Мэдээлэл, сургалт сурталчилгаанд 15000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулахаар төлөвлөн хэрэгжүүлж байна.

**B.4 Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр тооцогддоггүй ба ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого хуульд заасан хувь хэмжээний доод хязгаараас 40.1-45.5 хувиар доогуур тооцсон ч Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.4-т заасан арга хэмжээний хүрээнд зарцуулжээ.<sup>1</sup>**

Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлогыг тус аймагт тооцож, төвлөрүүлсэн асуудал аудитад хамрагдах сүүлийн 3 жилд гараагүй болно.

Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоос 2014 онд 9.9 хувь, 2015 онд 4.5 хувиар тус тооцсон нь байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хуульд заасан хувь хэмжээний доод хязгаараас 40.1-45.5 хувиар доогуур тооцсон байна.

<sup>1</sup> 3.1. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийг энэхүү журмын 2.2.1-д заасныг үндэслэн тухайн суманд:

3.1.1. нэн ховор, ховор ургамлын нөөцийн судалгаа шинжилгээ;

3.1.2. нэн ховор, ховор ургамлыг тарималжуулах, тархац нутгийг нөхөн сэргээх;

3.1.3. бэлчээрийн менежментийг сайжруулах, байгалийн ургамлын ашиглалтад хяналт тавих арга хэмжээнд тус тус зарцуулна.

3.4. Амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийг энэхүү журмын 2.2.2-т заасныг үндэслэн тухайн суманд:

3.4.1. аймгийн болон агуулын бус нутгийн ан, агуулын менежментийн төлөвлөгөө боловсруулах, сайжруулах, хэрэгжүүлэх, сурталчилах, нутгийн иргэдэд түшиглэсэн агуулын менежментийг хэрэгжүүлэх;

3.4.2. амьтны амьдрах орчинг нөхөн сэргээх, тэтгэх, агуулын амьтны судалгаа, мониторинг хийх;

3.4.3. Амьтны тухай хуулийг хэрэгжүүлэх нөхцлийг хангах сургалт, сурталчилгаа, хяналт шалгалт хийх арга хэмжээнд тус тус зарцуулна.



2014 онд ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд дараах зүйлд зарцуулсан байна. Үүнд:

- Ан амьтдыг хамгаалах чиглэлээр байгуулагдсан иргэдийн нөхөрлүүдийг чадваржуулах, үйл ажиллагааг дэмжихэд 3 төрлийн 2400.0 мянган төгрөг
- Мэдээлэл сургалт, сурталчилгаанд 4749.7 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.

2015 онд ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд дараах зүйлд зарцуулсан байна. Үүнд:

- Ан агуурын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад 2000.0 мянган төгрөг
- Мэдээлэл сургалт, сурталчилгаа, хяналтад 13197.3 мянган төгрөгийг зарцуулсан.

2016 онд ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд дараах зүйлд зарцуулахаар төлөвлөсөн байна. Үүнд:

- Мэдээлэл сургалт, сурталчилгаанд 15000.0 мянган төгрөгийг зарцуулж байна.

#### **B.5 Байгалийн нөөц ашигласны төлбөр төлөгчийг төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх нөхцөл, болзол, хувь хэмжээг орон нутгийн нөхцөл, онцлог байдлыг харгалзан хуульд заасны дагуу шийдвэрлэсэн байна.<sup>7</sup>**

Байгалийн нөөц ашигласны төлбөр төлөгчийг төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх нөхцөл, болзол, хувь хэмжээг хууль, журамд заасны дагуу тооцож ирсэн байна.

#### **Г. Байгаль хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд орон нутгийн удирдлага, хэлтэс, албадаас дотоод хяналтыг хуулийн дагуу зохих түвшинд хэрэгжүүлсэн байна.**

<sup>7</sup> 20 дугаар зүйл.Усны нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх

20.1.Дараах зориулалтаар ус ашигласан төлбөр төлөгчийг төлбөрөөс чөлөөлнө:

20.1.1.хүн амын унд, ахуйн хэрэгцээнд болон бэлчээрийн мал, амьтан, өрхийн хүнсний ногооны талбайг услах;

20.1.2.түмээр унтраах болон байгалийн бусад гамшигтай тэмцэх;

20.1.3.усыг үйлдвэрлэлийн технологийн хэрэгцээнд эргүүлэн ашигласан.

20.1.4.гадаргын усыг газар тариалангийн үйлдвэрлэлд ашигласан.

20.2.Дараах зориулалтаар ус ашигласан төлбөр төлөгчийн төлбөрийг Засгийн газраас тогтоосон хувь, хэмжээгээр хөнгөлж болно:

20.2.1.унд, ахуйн зориулалтаар усны эрдэсжилт, хатуулгыг нь цэнгэгжүүлж зөвлөрүүлэн ашигласан;

20.2.2.ан амьтан хамгаалах, ёсгэн үржүүлэх, нутагшуулах болон ургамал тарьж ургуулах замаар байгалийн баялгийг нөхөн сэргээх;

20.2.3.хаягдал ус цэвэрлэж, эргүүлэн ашигласан тохиолдолд тухайн хэмжээгээр;

20.2.4.цас, бороо, үерийн усыг хуримтлуулж мал аж ахуй, газар тариалангийн зориулалтаар ашигласан.

21 дүгээр зүйл.Оин нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх

21.1.Хилийн бүсийн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагч өөрийн албан ажлын байр барих зориулалтаар ойгоос хэрэглээний мод бэлтгэж ашигласан бол төлбөр төлөгчийг төлбөрөөс чөлөөлнө:

21.2.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ойд арчилгаа хийх, хожуул, унанги, үзүүр, мөчир, гишүү бэлтгэх зэрэг ойн цэвэрлэгээний аргаар хэрэглээнийн мод, тулээ бэлтгэж ашиглагав төлбөрийг хөнгөлж болох бөгөөд хөнгөлөлтийн хувь, хэмжээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

22 дугаар зүйл.Ан амьтны нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх

22.1.Төлбөрөөс дараах тохиолдолд чөлөөлнө:

22.1.1.ан амьтныг нутагшуулан үржүүлэх зориулалтаар барих;

22.1.2.халдварт өвчний голомтыг устгах зорилгоор эрүүл мэндийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр ан амьтныг мэргэжлийн байгууллагаас зохион байгуулалттай агнаж устгах;

22.1.3.мал сургийг хамгаалах болон тодорхой нутаг дэвсгэрт тоо толгойг нь сийрэгжүүлэх зорилгоор чоно агнах;

22.1.4.сорьц, дээж авах, хэмжилт хийх, им тэмдэг тавих, бөгжлэх, судалгааны хэрэгсэл зүүх зорилгоор ан амьтныг эрдэм шинжилгээнээс зориулалтаар түр барих.

22.2.Тодорхой нутаг дэвсгэрт ан амьтны тоог сийрэгжүүлэх, хийсийн харьцааг зохицуулах, заазлах зорилгоор болон соёл, шинжилгээнээс зориулалтаар агнахад төлбөрийг 80 хувь хүртэл хөнгөлж болно.



## Г.1 Хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдсэн байна.

Байгаль хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд Монгол улсын Засгийн газар, БОНХАЖЯам, аймаг, сумдын ИТХурал, Засаг дарга, БОАЖГазар, МХГазар, ОХБЦГазар, Онги-Таацын сав газрын захиргаа, Сум дундын ойн анги, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчид, Ойн нөхөрлөлүүд, иргэдийн бүлэг, Төрийн бус байгууллагууд хяналт тавихаар байгаль орчны багц хууль, тогтоомжид тусгаж, хэрэгжилтийг шат шатандaa зохион байгуулж ирсэн байна.

Тухайлбал аудитаар ажилласан Бат-Өлзий суманд байгаль орчны хяналтын улсын байцаагч-1, байгаль хамгаалагч-2, Ойн мэргэжлийн байгууллага -3, ойн нөхөрлөлүүд 24 ажиллаж байна. Хужирт суманд байгаль орчны хяналтын улсын байцаагч-1, байгаль хамгаалагч -2, Ойн мэргэжлийн байгууллага -2, нөхөрлөл, идэвхтэн, төрийн бус байгууллага ажилладаг.

Тарагт суманд байгаль орчны хяналтын улсын байцаагч-1, Уянга суманд байгаль орчны хяналтын улсын байцаагч-1, Байгаль хамгаалагч-2, нөхөрлөл 7, малчны бүлэг 2 , Хархорин суманд байгаль орчны хяналтын улсын байцаагч-1, байгаль хамгаалагч-2, Ойн мэргэжлийн байгууллага -1 байгаагийн зэрэгцээ сайн дурын нөхөрлөл ажилладаг байна.

Тиймээс хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдсэн гэж үзэж байна.

## Г.2 Байгаль орчныг хамгаалах хуулийн хэрэгжилтэд аймаг, сумдын Засаг дарга нар болон холбогдох хэлтэс, албад, байгаль орчны хяналтын улсын байцаагчид хяналтаа зохих түвшинд гүйцэтгэж ирсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас аймгийн БОАЖГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд 2015 онд дотоод аудит хийж, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд 2014 онд 121474.0 мянган төгрөгийг зарцуулахаар аймгийн ИТХТэргүүлэгчдээс баталсны гүйцэтгэлийг шалгаж, төлөвлөсөн ажлууд холбогдох хууль, журмын дагуу зарцуулсан талаар тайландаа дурдсан байна.

Онги-Таац голын сав газрын захиргаанд 2016 оны 6-р сард БОНХАЖЯамны Хяналт-Шинжилгээ, Үнэлгээ Дотоод аудитын газраас санхүүгийн хяналт шалгалт хийгдэж эерэг үнэлгээ өгчээ.

Аймгийн МХГазраас байгаль орчны хяналтын чиглэлээр 2014 онд 59 объектод шалгалт хийж, байгаль орчны чиглэлээр 15 хуулийн 61 заалт тэдгээр холбогдох стандарт, дүрэм журмын хэрэгжилтийг шалгажээ. Шалгалтаар Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилт 53.0 хувьтай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хэрэгжилт 73.0-81.0 хувь, “Агаарын тухай” хуулийн хэрэгжилт 73.0-87.0 хувь, Ойн тухай хуулийн хэрэгжилт 80.0 хувьтай гарсан байна.

Цэвэрлэх байгууламжид шалгалтыг Хархорин, Арвайхээр, Хужирт сумдын цэвэрлэх байгууламжуудад хийж эрсдлийг үнэлэхэд “Хархорин ус суваг” ОНӨААТҮГазар 37.1 хувьтай буюу дунд, Хужирт рашаан сувилал” ХХК 54.5 хувьтай, “Элма Хужирт” ХХК 52.9 хувьтай, “Онги ус суваг” ОНӨААТҮГазар 50.0 хувьтай буюу их эрсдэлтэй шалгагдаж, хуулийн хэрэгжилт 73.0-81.0 хувьтай гарсан байна.

Хужирт суманд үйл ажиллагаа явуулж байгаа Рашаан сувиллуудын рашааны худаг дээр халуун усны тоолуур суурилуулах, цэвэрлэх байгууламжийн байрлалын кадастрын зургийг гаргуулах, шинээр байгуулах цэвэрлэх байгууламжийн газар олголтын асуудлыг



шийдвэрлүүлж “Атмор” ХХК-иар цэвэрлэх байгууламжийн зураг төслийг хийлгэхээр шийдсэн. Гэвч цэвэрлэх байгууламжийн асуудал одоо хүртэл шийдэгдээгүй хэвээр байна.

Хууль бус ан агнуур, тэдгээрийн гаралтай түүхий эд зүйлийн худалдаалалт, тээвэрлэлтийн байдалд 8 суманд шалгалт хийж, зөрчил гаргасан 16 иргэнд захиргааны арга хэмжээний торгууль 6164.0 мянган төгрөг, агнуурын амьтны нөөцөд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр нийт 37338.0 мянган төгрөгийн нөхөн төлбөр ногдуулжээ.

Хяналт шалгалтын дунд ойн мэргэжлийн байгууллагууд гэрчилгээ, гэрээнд заасан үйл ажиллагаа явуулж, мод бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээг авч хэвшүүлсэн, Ойн ангиар талбай тусгаарлалт хийлгэж тусгаарласан талбайн нөөц, мөнгөн үнэлгээг тооцуулж, мод бэлтгэлийн ажил эхлэх, дуусгавар болгох акт үйлдэх, талбайгаа хүлээлгэн ёгч, мод бэлтгэлийн үед бэлтгэсэн мод, зусвэрт орсон модны бүртгэлийг өдөр тутам хөтөлж байгаль хамгаалагчид шалгуулдаг болсон байна.

Сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагчид тайлант хугацаанд байгаль орчны чиглэлээр үйл ажиллагааг түр зогсоосон акт 17, нөхөн төлбөр тогтоосон акт 89, эд зүйл устгасан акт 6, эд зүйл хураасан акт 71-ийг үйлдэж актын биелэлт 98.7 хувь, 40 заалт бүхий 26 албан шаардлага үйлдэж биелэлт 76.0 хувь, 15990.0 мянган төгрөгийн эд зүйлийг улсын орлого болгон хурааж 69 иргэн аж ахуйн нэгжид 67348.0 мянган төгрөгийн торгууль ногдуулж барагдуулалт 98.6 хувь, 65430.0 мянган төгрөгийн нөхөн төлбөр ногдуулж барагдуулалт 9.8 хувьтай гарсан байна.

2015 оны байгаль орчны бохирдлын хяналтаар 16, нөөцийн хяналтаар 16 нийт 32 объектод төлөвлөгөөт шалгалт хийхээр төлөвлөн ажиллажээ. Байгаль орчны бохирдол доройтлын хяналтаар 11 сумын 16 халаалтын зуухыг хамруулж 143 зөрчил илрүүлэн арилгуулсан. Байгаль орчны нөөцийн хяналтаар Ойн мэргэжлийн 6 байгууллага шалгалтанд хамрагдаж 32.0-40.0 хувийн дунд эрсдэлтэй үнэлэгдэж, 33 зөрчил илрүүлэн арилгуулсан байна.

Сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагчид ойн хяналтаар 25 аж ахуйн нэгж, 397 иргэн, ургамлын хяналтаар 476, амьтны хяналтаар 608, ус рашааны хяналтаар 56, ашигт малтмалаар 394, газрын чиглэлээр 135, хог хаягдлаар 45 иргэнийг урьдчилан сэргийлэх хяналтад хамруулан 7 дүгнэлт үйлдэж, албан шаардлага 45-ийг хүргүүлэн, биелэлт 71.1 хувьтай, үйл ажиллагаа зогсоосон акт 11, нөхөн төлбөр тогтоосон 27 акт үйлдэж, биелэлт 92.1 хувьтай байна.

Хууль бусаар бэлтгэсэн 104 м3 мод, түлээ, 434.9 кг байгалийн өнгөт чулууг улсын байцаагчийн актаар хураан улсын орлого болгож, 21203.3 мянган төгрөгийн нөхөн төлбөр ногдуулж, 8 иргэнд эрүүгийн хэрэг үүсгэн шалгуулахаар цагдаагийн байгууллагад шилжүүлжээ.

2015 онд 58 аж ахуйн нэгж, иргэнд 40947.0 мянган төгрөгийн торгууль ногдуулсанаас 31817.0 мянган төгрөг барагдуулсан, 17994,0 мянган төгрөгийн нөхөн төлбөр ногдуулж, 14677.0 мянган төгрөгийг барагдуулсан байна.

2016 оны эхний хагас жилийн байдлаар байгаль орчны бохирдлын хяналтаар 19 халаалтын зуух, 4 цэвэрлэх байгууламжид хяналт шалгалт хийжээ. Хяналт шалгалтаар 207 зөрчил илрүүлж, 97 заалт бүхий 17 албан шаардлага үйлдсэн байна.



Байгаль орчны нөөцийн хяналтаар 13 объектод шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах 47 заалт бүхий 6 албан шаардлага, үйл ажиллагааг түр зогсоосон акт 3-ыг үйлдэж аж ахуйн нэгжүүдийн удирдлагад хүргүүлсэн байна.

2016 оны хагас жилийн байдлаар сумдад байгаль орчны хяналт шалгалтанд 33 хуулийн этгээд, 783 иргэн хамрагджээ. Шалгалтаар 18847.0 мянган төгрөгийн нөхөн төлбөр ногдуулсны 5573.0 мянган төгрөг, 24 зөрчилд 20422.0 мянган төгрөгийн торгууль ногдуулсны 16 зөрчлийн 14802.0 мянган төгрөгийн торгуулийг барагдуулсан байна.

Байгаль орчныг хамгаалах хуулийн хэрэгжилтэд аймаг, сумдын Засаг дарга нар болон холбогдох хэлтэс, албад, байгаль орчны хяналтын улсын байцаагчид хяналтаа зохих түвшинд гүйцэтгэж ирсэн байна.

## ДҮГНЭЛТ

*Тус аймагт байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хөрөнгийг хуульд заасан хувь хэмжээгээр тооцдоггүй, байгаль орчныг бохирдуулж, доройтуулах зөрчлүүд гарсаар байна.*

**A. Аймгийн ИТХурал болон Засаг даргаас байгаль орчныг хамгаалах талаар хуульд заасан үүргээ хэрэгжүүлж ажилласан ч байгаль орчныг бохирдуулах, доройтуулах зөрчлүүд гарсаар байна.**

А.2 Аймгийн ИТХурал нь нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохицой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөө баталж, биелэлтэд хяналт тавих бүрэн эрхээ хэрэгжүүлж ирсэн байна.

А.3 Аймгийн Засаг дарга нь нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохицой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ боловсруулж, аймгийн ИТХуралд өргөн мэдүүлж, гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулан ажиллаж байгаа ч байгаль орчныг бохирдуулах, доройтуулах зөрчлүүд гарсаар байна.

**B. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу төлөвлөсөн ч төлөвлөлтийн үндэслэл бодитой биш, орлогын гүйцэтгэл төлөвлөснөөс 3.6-4.1 хувиар тасарсан байна.**

Б.1 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлтийн үндэслэл бодитой биш байна.

Б.2 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэл сүүлийн 3 жилийн байдлаар 95.9-96.4 хувийн биелэлттэй буюу төлөвлөснөөс 3.6-4.1 хувиар тасарсан үзүүлэлттэй гарсан байна.

**В. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хуваарилсан хөрөнгө хуульд зааснаас доогуур хувиар тооцсон ч хуваарилсан хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу зарцуулсан байна.**



- В.1 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хувь хэмжээг хуульд зааснаас 2014 онд 2.1-40.1 хувь, 2015 онд 0.6-79.0 хувиар тус тус доогуур тооцсон байна.
- В.2 Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээний доод хязгаараас 2.1-79.0 хувиар доогуур тооцож, Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.3-т заасан арга хэмжээний хүрээнд зарцуулсан байна.
- В.3 Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээний доод хязгаараас 0.6-29.7 хувиар доогуур тооцсон боловч Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.2-т заасан арга хэмжээний хүрээнд зарцуулсан байна.
- В.4 Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр тооцогддоггүй ба ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого хуульд заасан хувь хэмжээний доод хязгаараас 40.1-45.5 хувиар доогуур тооцсон ч Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.4-т заасан арга хэмжээний хүрээнд зарцуулжээ.
- В.5 Байгалийн нөөц ашигласны төлбөр төлөгчийг төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх нөхцөл, болзол, хувь хэмжээг орон нутгийн нөхцөл, онцлог байдлыг харгалзан хуульд заасны дагуу шийдвэрлэсэн байна.

**Г. Байгаль хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд орон нутгийн удирдлага, хэлтэс, албадаас дотоод хяналтыг хуулийн дагуу зохих түвшинд хэрэгжүүлсэн байна.**

Г.1 Хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдсэн байна.

Г.2 Байгаль орчныг хамгаалах хуулийн хэрэгжилтэд аймаг, сумдын Засаг дарга нар болон холбогдох хэлтэс, албад, байгаль орчны хяналтын улсын байцаагчид хяналтаа зохих түвшинд гүйцэтгэж ирсэн байна.



## ЗӨВЛӨМЖ

**Аймгийн Засаг дарга Г.Ганболдод**

- Байгаль орчныг хамгаалах талаар хуульд заасан бүрэн эрхээ бүрэн хэрэгжүүлж, байгаль орчинд тавих хяналтаяа сайжруулах.
- Орхон голын эхэнд холбогдох зөвшөөрөлгүй, хууль бус үйл ажиллагаа явуулж байгаа алтны уурхайнуудын үйл ажиллагааг зогсоох, тусгай зөвшөөрлийг цуцлах, аж ахуйн нэгжүүдийн байгаль орчинд учруулсан хохирлыг арилгуулах. нөхөн сэргээлт хийлгэх талаар холбогдох шатны байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөөвлөлтийн үндэслэлийг сайжруулах.
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоо орон нутгийн төсөөт бүрэн төвлөрүүлж, хэлтэс албадын ажлын уялдаа холбоог хангаж ажиллах.
- БОНХАЖС-ын 2015 оны №А-323 тушаалаар баталсан “Ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлсийг тогтоосон хэмжээний үндэслэл. хэрэгжих нөхцөл боломжийг судлан хөлсийг багасгах талаар хүсэлт, саналаа тус яаманд хургүүлж, шийдвэрлүүлэх.
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь хэмжээг хуульд заасан доод хэмжээнээс бууруулахгүйгээр төлөөвлөн аймгийн ИТХ-аас батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.РӨНЦЭНХАНД

АУДИТЫН МЕНЕЖЕР ЧОИГОННИЯМ

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР Д.ГАНСҮХ

АУДИТОР

П.ХОРЛООСҮРЭН

ШИНЖЭЭЧ О.Б. О.РИНЧИНМЯДАГ



**ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ БОАЖГ-ЫН 2016  
ОНЫ 10 ДУГААР САРЫН 10-НЫ №116 ТООТООР ИРҮҮЛСЭН САНАЛД ДАРААХ  
ТАЙЛБАРЫГ ӨГЧ БАЙНА.**

**Аймгийн Засаг даргын дэргэдэх БОАЖГ-аас ирүүлсэн албан тоотод:**

1. 2015-2016 онд тус аймагт хушны самар элбэг ургасан жил тохиолдож байгаатай холбогдуулж ой ашигласны төлбөрийн орлого 823.0 сая төгрөг болж өссөн. Үүнийг ойгоос мод түлээ бэлтгэж ашигласны, ойн дагалт баялаг ашигласны төлбөр гэдгээр нь ангилж зааглах шаардлагатай.
2. Байгалийн баялаг ашигласны төлбөрийн орлогоос зөвхөн улсын болон орон нутгийн төсвөөс зарцуулахаар тухайн жил төлөвлөсөн байгаль орчныг нөхөн сэргээх, хамгаалахад зарцуулж буй зардлыг тооцсон нь учир дутагдалтай байна. Үүнд: сумдад түймэр, хөрөөлт шавж, хууль бус ажиллагаатай тэмцэхэд гарсан зардлууд, байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагчдад унаа, ажлын хувцас, бие хамгаалах хэрэгсэл, бусад техник хэрэгсэл авахад зарцуулсан зардлыг нэмж тооцох нь зүйтэй.
3. Тайлангийн 17 дугаар хуудсанд Хужирт, Хархорин, Бат-Өлзий, Уянга, Тарагт сумдад байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажилд хөрөнгө зарцуулаагүй байна гэжээ. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас сүүлийн 3-н жилд дээрх сумдад ойжуулалт, уул уурхайн нөхөн сэргээлт, ойн зурvas байгуулах зэрэг ажилд хөрөнгө төлөвлөж, зарцуулсан болно.
4. Хуулийн дагуу байгаль орчныг нөхөн сэргээх, хамгаалахад зарцуулах хөрөнгийг төлөвлөхөд Татвар, Төрийн сангийн ажилтнуудын ажлын уялдаа холбоо, оролцоог хангаж ажиллах шаардлагатай талаар дүгнэлтэд тусгах.
5. Рашаан ашиглагч аж ахуйн нэгжүүдийн ус, рашаан ашигласны дүгнэлтийг “Монгол Ус” ТӨҮГазраар гаргуулж, Архангай аймагт байрлаж байгаа сав газрын захиргаанаас ус ашиглуулах зөвшөөрлөө авч байгаа нь аж ахуйн нэгжүүдэд маш хүндрэлтэй, мөн ус ашиглуулах дүгнэлтээ үндэслэл муутай гаргаж байгаа нь төлбөрийн орлогыг тасалдуулах нэг үндэслэл болж байна.

**Албан тоотын хариу болгож дараахаар шийдвэрлэв.**

1. Тайлангийн 14 дүгээр хуудсанд “2015 онд ойгоос мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогоор 823759.5 мянган төгрөгийг төсөвт оруулсаны 78100.0 мянган төгрөг нь мод түлээ бэлтгэж ашигласны, 745659.5 мянган төгрөг нь ойн дагалт баялаг /самар/ ашигласны төлбөрийн орлого байна”гэж нэмж оруулав.

2. Сумдад зарцуулсан түймэр, хөрөөлт шавж, хууль бус ажиллагаатай тэмцэхэд гарсан зардлууд, байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагчдад унаа, ажлын хувцас, бие хамгаалах хэрэгсэл, бусад техник хэрэгсэл авахад зарцуулсан зардал нь сумдын төсвийн урсгал зардал болон Байгаль хамгаалах сангаас зарцуулагдаж байгаа тул хүлээн авах боломжгүй байна.

3. Хужирт, Хархорин, Бат-Өлзий, Уянга, Тарагт сумдууд тухайн сумын төсөвт орсон байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажилд хөрөнгө зарцуулаагүй байсан тул хүлээн авах боломжгүй байна. Харин улс, аймгийн төсвөөс дээрх сумдад зарцуулсан хөрөнгийг тайландаа дурдсан болно.

4. Хэлтэс албадын ажлын уялдаа холбоог хангаж ажиллах талаар зөвлөмжид тусгав.



## АЛБАН ШААРДЛАГА



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2016 оны 10 сарын 07Дугаар 01/810

Аудиторын

Аймгийн Засаг дарга Г.Ганболд-д  
зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу Өвөрхангай аймагт Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд нийцлийн аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн "Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогыг хувь, хэмжээний доод хязгаарыг байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого 15 хувь, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого 50 хувь, ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 85 хувь, ус, раашаны нөөц ашигласны төлбөрийн орлого 35 хувь" гэсэн заалтуудыг зөрчиж байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хувь хэмжээг хуульд зааснаас 2014 онд ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос 82.9 хувиар, ус раашаны нөөц ашигласны орлогоос 5.3 хувиар, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоос 9.9 хувиар тооцсон нь 134330.8 мянган төгрөгөөр, 2015 онд ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос 6.0 хувиар, ус раашаны нөөц ашигласны орлогоос 34.4 хувиар, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоос 4.5 хувиар тооцсон нь 805461.1 мянган төгрөгөөр тус тус дутуу тооцсон зөрчил илрэв.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-д заасан "Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлагагаа өгөх", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны A/95 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт, албан шаардлагаа өгөхөд баримтлах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1-д заасан "Төрийн аудитын байгууллагасын агуулцэтгэж байгаа аудитын дунд шалгагдагч байгууллагын удирдлагагас тодорхой арга хэмжээг богино хугацаанд авч хэрэжжүүлэх нь тухайн алдаа, зөрчлийг таслан зогсоож, дэвтэн гаргуулахгүй байхад чухал үр нөлөөтэй гэж үзэн алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд акт, албан шаардлагагаа өгнө" гэсэн заалтуудыг тус тус үндэслэж ШААРДАХ нь:



Цаашид байгалийн неэц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээний доод хязгаарыг баримтлан төлөвлөж, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулж байх талаар тодорхой ажил зохион байгуулан дээрх зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2016 оны 12 дугаар сарын 25-ны дотор аймгийн Аудитын газарт албан ёсoor ирүүлэхийг аймгийн Засаг дарга Г.Ганболд, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Д.Нэмэхбаяр нарт даалгав.

## АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН

ЗӨВШӨӨРСЕН


АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
АХЛАХ АУДИТОР Д.ГАНСҮХ  
АУДИТОР Н.ХОРЛООСҮРЭН  
ШИНЖЭЭЧ ӨРИНЧИНМЯДАГ

АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГА Г.ГАНБОЛД  
СТСХ-ИЙН ДАРГА  
Д.НЭМЭХБАЯР

Албан шаардлагыг зассан хувцасанд хэрэгжүүлсэгүү тахилдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дулаар зүйлийн 28.2.2 төрийн аудитын байгуулласын төвийн албан шаардлагыг, төлбөрийн актыг цаг хувцасанд нь биелүүлжсөүү тахилдолд зөрчил авраасан албан тушаалтныг уурзат ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгуулласаа эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ."



Аймгийн аудитын таармын 2016 оны  
10 дугаар сарын 09-ны өдрийн  
дугаар албан шаардлагын хави



Өвөрхангай аймагт 2014 онд байгалийн нөөц ашигласны төлбөрөөс  
байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийн тооцоо

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Байгалийн ургамал ашигласны төлбөр /30%/	Ойн нөөц ашигласны төлбөр /85%/	Ус, рашааны нөөц ашигласны орлого/35%	Ан амьтаны нөөц ашиласны орлого /50%/	Дүн
1	БНАТөлбөрийн дүн	-	115914.3	346618.8	71922.2	534455.3
2	Нөхөн сэргээхэд зарцуулбал зохих	-	98527.155	121316.58	35961.1	255804.84
3	Зарцуулсан	-	96074.7	18249.7	7149.7	121474.07
4	Хувь	-	97.5	15.0	19.9	47.5
	Нөөцийн төлбөрөөс нөхөн тооцсон хувь	-	82.9	5.3	9.9	

Өвөрхангай аймагт 2015 онд байгалийн нөөц ашигласны төлбөрөөс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийн тооцоо

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Байгалийн ургамал ашиласны төлбөр /30%/	Ойн нөөц ашиласны төлбөр /85%/	Ус, рашааны нөөц ашиласны орлого/35%	Ан амьтаны нөөц ашиласны орлого /50%/	Дүн
1	БНАТөлбөрийн дүн	-	823759.5	290968.2	336657.2	1451384.9
2	Нөхөн сэргээхэд зарцуулбал зохих	-	700195.6	101838.9	168328.6	970363.05
3	Зарцуулсан	-	49507.3	100197.3	15197.3	164901.93
4	Хувь	-	7.1	98.4	9.0	17.0
	Нөөцийн төлбөрөөс нөхөн тооцсон хувь	-	6.0	34.4	4.5	